



1889 ОНЫ МЕЙЖИГИЙН ЭРИН ҮЕИЙН ЯПОН УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ 1924 ОНЫ МОНГОЛЫН ҮНДСЭН ХУУЛЬД ТУССАН НӨЛӨӨ

THE INFLUENCE OF THE 1889 MEIJI CONSTITUTION OF JAPAN ON THE 1924 CONSTITUTION OF MONGOLIA

Цэдэндамбын Батбаяр¹

Mongolian Academy of Sciences, Shihihutug University, E-mail: batbayar@shihihutug.edu.mn,
<https://orcid.org/0000-0001-7259-9540>

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

Түлхүүр үгс:

Мэйжигийн эрин үе, Японы үндсэн хууль, хэмжээт цаазат, хаант засаглал, иргэдийн эрх, эрх чөлөө

Keywords:

the Meiji era, Japanese Constitution, constitutional monarchy, rights and freedoms of the citizens

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2025, 10 сар
Шинэчилсэн: 2025, 10 сар
Зөвшөөрсөн: 2025, 10 сар

Article history:

Received Oct, 2025
Revised Oct, 2025
Accepted Oct, 2025

ХУРААНГУЙ

Үндсэн хууль боловсруулах Н.Магсаржав тэргүүтэй анхны комисс Судар бичгийн хүрээлэнд захиалга өгч хэд хэдэн гадаад орны үндсэн хуулийг орчуулснаас өнөөгийн байдлаар ҮТНС-нд Америк, Англи, Япон, Норвег улсын үндсэн хуулийн орчуулга хадгалагдаж байна.

Яагаад 1920-иод оны Үндсэн хуулийг боловсруулагчид Мейжийн Японы Үндсэн хуулийг сонирхон судалж, монгол хэлээр орчуулах болов? гэсэн асуулт гарч байна. Юуны өмнө Мейжийн Япон Эзэн хаантай, Хаан нь хэмжээт цаазтай, мөн Улсын хурал буюу парламенттай улс байсан нь гол шалтгаан болно.

Монголын Үндэсний үзэлтнүүдийн мөрөөдөл бол “Хэмжээт цаазат, ардын эрхт” тогтолцоог хүсэж байв. Тэр нь Англи, Японд байсан шиг Эзэн хаантай парламентын Бүгд Найрамдах Улсыг баримжаалж байсан гэж хэлж болно. Хэмжээт цаазат Эзэн хаан ба Улсын хурал буюу парламентын эрх мэдлийн харьцааны асуудал тухайн үед онцгой анхаарал татаж байв.

Хоёрт, Мейжийн Японы Үндсэн хуульд туссан байсан албат иргэдийн эрх, эрх чөлөөний асуудал манай хууль боловсруулагчдын хувьд үлгэр жишээ болж байсан гэж үзэж болно. Тухайлбал, үг хэлэх, бичих ба өөрийн санал дэлгэрүүлэх, хоршоо холбоо байгуулах эрх (Японы Үндсэн хуулийн 2-р бүлэг, 29-р зүйл), Японы ард хэн ч болов бичиг, цэргийн тушаал эдлэх эрх (19-р зүйл), шашин шүтлэгийн эрх чөлөө эдлэх эрх (Японы ҮХ-ийн 28-р зүйл), Японы албат нарын өөр өөрийн өв хөрөнгийн эрх дор халдаж болохгүй (Японы ҮХ-ийн 27-р зүйл) зэргийг нэрлэж болно.

Abstract

The committee tasked with drafting Mongolia's first Constitution, under the leadership of N. Magsarjav, requested the Learned Society of Mongolia to translate the constitutions of several foreign countries, including those of the United States, England, Japan, and Norway. These translations remain preserved in the Public Library of Mongolia

¹Академич, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D), Шинжлэх ухааны академийн гишүүн, Шихихутуг их сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүн.

to this day. When drafting Mongolia's first Constitution in the 1920s, the committee chose the Meiji Constitution of Japan as a principal model and undertook its translation into Mongolian. In their view, Japan represented a monarchy whose authority was effectively balanced and regulated by a comparatively stronger parliamentary system.

The vision of Mongolian nationalists during this period was a system of "people's power" under a constitutionally limited monarch. They looked to models such as England and Japan, where constitutional monarchies operated within robust parliamentary frameworks. The balance of authority between monarch and parliament emerged as the central concern for the drafters of Mongolia's new Constitution.

Secondly, the rights and freedoms enshrined in the Meiji Constitution exerted a profound influence on the initial drafts of Mongolia's Constitution. Notably, the provisions guaranteeing Japanese subjects the liberty of speech, writing, publication, public meetings, and associations (Article 29, Chapter 2); equal eligibility for appointment to civil, military, or other public offices (Article 19, Chapter 2); freedom of religion (Article 28, Chapter 2); and the right to private property (Article 27, Chapter 2) served as particularly inspiring models for the Mongolian drafters.

Энэ өгүүлэл [CC BY-NC](#) лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



1. Танилцуулга

1920-иод онд Монгол Улс тусгаар тогтносон шинэ улсын Үндсэн хуулийг боловсруулахдаа олон улсын эрх зүйн туршлага, ялангуяа Европ, Америкийн улс орнуудын загварт тулгуурлан судалгаа явуулсан билээ. Энэ хүрээнд Судар бичгийн хүрээлэнгээр дамжуулан орчуулсан гадаад улс орнуудын дундаас 1889 оны Мэйжигийн Японы Үндсэн хууль онцгой анхаарал татсан бөгөөд Монголын 1924 оны Үндсэн хуулийн үзэл баримтлал, бүтэц, иргэдийн эрхийн зохицуулалтад мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн байна.

Японы Мэйжигийн Үндсэн хууль нь эзэн хаантай боловч парламентын хяналтад тулгуурласан хэмжээт цаазат тогтолцоог илэрхийлдэг бөгөөд энэ нь “ардын эрхт, хэмжээт цаазат” загварыг эрэлхийлж байсан Монголын үндэсний сэргэн мандлын төлөөлөгчдөд оновчтой жишиг болжээ. Мөн тус хуулийн иргэдийн суурь эрх үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэл байгуулах, шашин шүтэх, өмчлөх, төрийн албанд тэгш эрхтэйгээр ажиллах боломж нь Монголын анхны Үндсэн хуулийн төслийн “Ардын эрх ба үүргийн тухай” бүлгийн агуулгад тод мэдрэгддэг.

Иймээс энэхүү өгүүлэл нь Мэйжигийн Үндсэн хуулийн бүтэц, эрх, эрх чөлөөний зохицуулалт Монголын 1924 оны Үндсэн хуульд хэрхэн нөлөөлснийг архивын эх сурвалж, орчуулгын баримт, харьцуулсан эрх зүйн судалгаанд тулгуурлан товчхон шинжилнэ.

2. Арга зүй

Судалгаанд түүхэн эх сурвалжийн шинжилгээ болон харьцуулсан эрх зүйн аргыг хослуулахын зэрэгцээ баримтад тулгуурлан олон эх сурвалжид суурилан судалгааны найдвартай байдлыг хангаж, Мэйжигийн Үндсэн хуулийн Монголын эрх зүйн шинэчлэлд үзүүлсэн нөлөөг академик түвшинд тодорхойлох боломжийг эрэлхийлсэн болно.

3. Судалгааны үр дүн

Үндсэн хуулийг боловсруулах ажлыг 1922 оны зун цагаас албан ёсоор эхлүүлжээ. Олноо өргөгдсөний 12-р оны 5 сарын 19-ны өдөр буюу 1922 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн Засгийн газрын 21 дүгээр хурлаас Шүүх яамны тэргүүн сайд Н.Магсаржав тэргүүтэй, Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн Ж.Цэвээн, түшмэл Бат-Очир нарын бүрэлдэхүүнтэй Үндсэн хууль боловсруулах анхны комиссыг томилжээ. Уг хурлын тогтоолд: “Манай Монгол улс ардын эрхт хэмжээт цаазат засгийг явуулж буй боловч үндсэн хууль зүйлийг тогтоон гүйцэтгээгүй нь аливаа хэргийг шийтгэж явуулах дор их л дутагдах газар буй амуу. Үүнд одоогоос тусгай комисс томилон гаргаж, урьд автономит засгийн үед зохион төлөвлөж гаргасан журамлан явуулах хууль цаазын бичгээс авах гээхийг ялган салгаж, ...эрхбиш Европын олон улсын хууль дүрмийг харгалзан ...энэхүү хэрэгт шүүх яамны тэргүүн сайд Магсаржав, Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн Ж.Цэвээн, түшмэл Бат-Очир нарыг тусгайлан томилж, Шүүх яамнаас эрхлэн гурван сарын дотор хянан зохицуулж гүйцэтгүүлэхээр тогтов” гэжээ.¹

Түүхч М.Санждорж бичсэнээр тус комисст АЗГ-ын 1922 оны 9 дүгээр сарын 1-ний Засгийн газрын 39-р хурлаас “Үндсэн хуулийг ардын эрхт хэмжээт цаазат Англи мэт улсын хуулиас товчлон авч эдүгээгийн явуулан буй засгийн байдалд нийлүүлэн зохиовол зохино” гэсэн удирдамж нэмж өгчээ. Тус комисс Англи, Швед, Бельги, Голланд зэрэг улсын үндсэн хууль ба үндсэн хуулийн чанартай актууд, мөн хөрөнгөтөн орны үндсэн хуулийн хөгжлийн тухай судалгааны бичиг зохиолыг орчуулах, судлах ажил хийжээ. Үндсэн хуулийн комисс нэлээд ажлыг гүйцэтгэсэн боловч АЗГ-аас товчлон заасан хугацаанд уг хуулийн төслийг боловсруулж чадаагүй, амжаа ч үгүй байна. Иймд АЗГ тэр комиссыг татан буулгаж /1922 оны 12 сарын 29-нд-Ц.Б./, тэрхүү ажлыг Засгийн газрын хууль цаазыг эмхлэх хэлтэст хавсран гүйцэтгүүлэхээр тогтжээ.²

1920-иод оны эхээр шүүх цаазын шинэчлэл хийж, хуулийн өмнө иргэн бүр тэгш эрхтэй байх зарчмыг тунхаглаж, цагдаагийн байгууллага, дотоодыг хамгаалах газар зэрэг хүчний байгууллагуудыг бий болгож, байнгын армийн үндсийг бүрэлдүүлсэн байна. Орон нутагт ардын эрхт засаг төрийн байгууллагуудыг бий болгон бэхжүүлэх ажил өрнөв. 1923 оны эхээр Засгийн газраас “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм”, “Засаг ба засаг бус ван гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм” батлан гаргасан нь орон нутагт шинэ засгийн тогтолцоог бий болгох хууль эрхийн үндсийг тавьжээ. 1923-1924 онд Засгийн газраас нутгийн захиргааг өөрчлөн байгуулах ажлыг явуулж, арван гэр, отог, сум, хошуу, аймагт ардын хурлыг байгуулжээ. Арван гэрийн захиргаанд лам, ноёд,

¹ МУУТА, ТБА. Х-1, Д-1, ХН-80, х.171-173.

² М.Санждорж. Ардын төрийн түүх. УБ., 1974, х.135-136.

тайж, ард хэн боловч захирагдах болов. Ноёд, тайж нар иргэдийн нэгэн адил сонгох, сонгогдох эрх эдэлж байлаа.

Түүхч Ч.Дашдаваа 1920-иод оны эхэн үеийн “Улс төрийн салбар дахь өөрчлөлт нь Монгол оронд бүгд найрамдах засаг тогтоож, хуулийг дээдлэх үзэл санааг нийгэмд төлөвшүүлэн, улмаар Монголд парламентын ёсыг бүрэлдүүлэх утвар нөхцөлийг бий болгосон байна. Нийгмийн гишүүд гарал угсаа, хөрөнгө чинээний байдлаас үл хамааран адил тэгш эрхтэй болсон нь ардчилсан өөрчлөлтийн нэн чухал ололт байв. Төр шашны харилцааг хуулиар зохицуулах, ард олны шүтэх бишрэх эрх чөлөөг төрөөс хангаж байсан бөгөөд монголын нийгэмд олон ургалч үзэл төлөвшиж эхэлжээ” гэж үзсэн байна.³

Үндсэн хууль боловсруулах Н.Магсаржав тэргүүтэй анхны комисс Судар бичгийн хүрээлэнд захиалга өгч хэд хэдэн гадаад орны үндсэн хуулийг орчуулуулснаас өнөөгийн байдлаар ҮТНС-нд Америк, Англи, Япон, Норвег улсын үндсэн хуулийн орчуулга хадгалагдаж байна. Түүхч З.Лонжид эдгээр хуулийн заримыг орос хэлнээс, заримыг англи, япон эхээс нь шууд монголчилсон байх магад гэж үзжээ. Тэр бээр үзэхдээ хориод оны эхэн үед манай улсын нам төр, олон нийтийн байгууллагад янз бүрийн алба хашиж байсан Ц.Дамбадорж, Н.Жадамба, Цогтбадамжав, Гомбобадамжав, Алтан-Очир, Д.Буддарь,

Г.Галон, Ж.Цэвээн зэрэг англи, япон хэл бичигт сайтар суралцсан хүн цөөнгүй байсан нь ингэж үзэх боломжтой гэжээ. 4

“Олон улсын Үндсэн хуулийн оршил ба Англи, Америк, Япон, Норвег улсын үндсэн хуулийн дэвтэр” хэмээх 102 хуудастай гар бичмэлд 6 төрлийн хууль зүйлийг багтаажээ. Эхний 15 хуудас бүлэг нь “Олон улсын үндсэн хуулийн оршил” хэмээх гарчигтай бөгөөд ХҮШ зууны эцэс хүртэл буюу дундад зууны Европын орнуудын улсын хурлын тухай танилцуулгыг багтаасан бөгөөд Умард Америкийн Холбоот улсын хэмжээт Үндсэн хууль, Францын улс, Шведийн хаант улс, Австрийн хаант улсын үндсэн хуулийн тухай тайлбарыг өгүүлжээ. 5

Уг оршил бичигт: “ХҮШ зууны эцэс хүртэл Их Европын олон газар эртнээс эзэнт засаг явуулахаас өөрийг үл хэрэглэх бүлгээ. Франц улсын орон нутгийн төлөөлөгчид түшмэдийн хурал, Испани дахь конгресс хэмээх хурал, Герман дахь муж улс ба хот улсын хурлууд эрт цагаас цааз хууль зохиож үндсэн жургаан мэт нэгэн буй ...боловч XIX зууны үес дор цөм гээгдэн хасагдаж гагцхүү Швейцарын хот кантон ба Нидерланд хийгээд Германы хэдэн сул хот ба Швед, Полони, Венеци дор үлдсэн нь тус тусын эзэрхэг хотын хүчин дор эвдэгдэхийн аюул их бүлгээ” гэжээ. Цааш нь “Хэмжээт цаазтыг дэлгэрүүлсүгэй хэмээсэн их явдлуудын дотор Австрийн үндсэн хууль нь их оновчтой болмуй. Гэтэл бас Шведийн хурлын тухай хэвийн хуулийг 1877 онд хувьсган зассан ба Финлянд хэмээх Оросын харьяат бага улсад ардын төлөөлөгчдийн хурлыг 1879 онд нээснээс энэ хоёр явдал болбаас судар дор чухал тэмдэглэвээс болмуй” гэсэн байна.

³ Ч.Дашдаваа. Улаан түүх (Коминтерн ба Монгол). УБ., 2003, х. 85.

⁴ З.Лонжид. Түүх сөхөхүй. Эмхэтгэл. УБ., 2011, х.351.

⁵ Олон улсын Үндсэн хуулийн оршил ба Англи, Америк, Япон, Норвег улсын үндсэн хуулийн дэвтэр. Үндэсний төв номын сан. Шифр 2898/96 цахим эх. Нийт 102 тал.

Оршил бичгийн төгсгөлд “Жич Англи улсын маш олон бөгөөд их колони газрууд үйлдэхүй ер Европын хүчирхэг улсууд харьяат колониуд гол газраас шууд нугалан захирч засгийн эрх мэдлийг бүрнээ гол газар чандлан барих бөгөөтөл Англи улс ер гол засгийн газрын эрх мэдлийг шууд олон колониуд дор явуулсугай хэмээх үгүй тэр байтугай сүүлийн 50 жил дотор Англи улс өөрийн харьяат олон колони газар орны төлөөлөгчдийн хурал нээж, газар орон бүрийн суртал боловсрол ба хүч чадал, зан суртлыг гаргаж хурлын эрх мэдлийн хэмжээг хэдэн зэргээр ялган салгаж тус бүр зохилдуулахыг хичээмүй. Бүрэн бүтэн улсад өөр болох Канад, Австри зэргийн хуулиуд нь ...автономи зэргийг алдмуй. Португал зэрэг газар нь цэргийн чанд хуулиар захирагдмуй. Энэ хоёрын хооронд газар орны эрх чанар ба ард амьтны боловсрол, баян хоосон ... адилгүй учир тухай бүр хянан үзэж цаг дор нийлүүлэн олон зэрэг дэвийн эрх мэдлийн захиргаа олгосон нь маш гайхамшигтай мэргэн засгийн бодлого бөгөөд гол газраас харьяат колониудыг дотлолон дэлгэрүүлсүгэй хэмээн үзсэний бэлхэн гэрч мөн буюу хэмээн оршил бичсэн ану төгсөв” гэжээ.6

Тус дэвтрийн 2, 3 дугаар хэсэгт Англи улсын үндсэн хуулийн орчуулгыг багтаажээ. Үүнд 1215 оны Магна Хартын товч орчуулга ба 1225 онд III Хэнри хааны заларсан их Харт бичгийн товч орчуулгыг оруулсан байна. 4 дүгээр хэсэгт Норвег улсын Үндсэн хуулиас улсын хурлын тухай зүйлүүдийг түүвэрлэн бичсэн байна. 5 дугаар хэсэгт Хойд Америкийн Холбоот улсын үндсэн хууль, 6 дугаар хэсэгт Япон улсын үндсэн хуулийг бүрэн бүтнээр нь орчуулсан байна.

1215 онд анх зохиогдсон Английн “Магна Харт”-д туссан гол санаануудыг дурдвал: сүм хийдийн халдашгүй бие даасан байдал, эрхийг хамгаалан баталгаажуулах, газрын эзэд, язгууртан тэдгээрийн хоорондын болон тэдгээрээс албат нартай үүссэн маргаанд Эзэн хааны оролцоог халах, хүний амьдралын үндсэн эх сурвалж болсон үл хөдлөх хөрөнгийг өрөнд болон гэмт хэргийн торгуульд хураан авахыг хориглох, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангах, шүүхийг Эзэн хааны нөлөөнөөс ангид байлгах, хааны болон түшмэд нарын дур зоргоор авирлахыг хязгаарлаж, шүүхээр хянаж байх, чөлөөт иргэний эрх чөлөө, түүнийг шүүхээр хамгаалах, улс орноо нээлттэй байлгах зэрэг олон асуудлыг зохицуулж байв.7

1889 оны Японы анхны үндсэн хуулийн орчуулга 7 бүлэгтэй 76 зүйлтэй бөгөөд 1-р бүлэг: Эзэн императорын тухай зүйлүүд, 2-р бүлэг: Албат иргэний эрх ба үүргийн тухай, 3-р бүлэг: Улсын хуралдааны тухай, 4-р бүлэг: Улсын тэргүүн сайдууд ба Нууц зөвлөлийн тухай, 5-р бүлэг: Зарга шийтгэх тухай, 6-р бүлэг: Улсын санхүүгийн тухай, 7-р бүлэг: Нэмсэн зүйлүүд гэсэн гарчигтай ажээ.8 Энэхүү орчуулгыг нэг бол англи хэлнээс, эс бол орос хэлээр дамжуулан орчуулсан болов уу гэж таамаглаж байна. Мөн япон хэлнээс шууд орчуулсан байж болох ч баримт байгаа юм.*

⁶ Олон улсын Үндсэн хуулийн оршил ба Англи, Америк, Япон, Норвег улсын үндсэн хуулийн дэвтэр. х. 3-14.

⁷ Магна Харт. Орчуулсан П.Амаржаргал, Редактор Н.Лундэндорж. УБ., 2012, х.8-9.

⁸ Олон улсын Үндсэн хуулийн оршил ба Англи, Америк, Япон, Норвег улсын үндсэн хуулийн дэвтэр. Үндэсний төв номын сан. Шифр 2898/96 цахим эх. Нийт 102 тал.

* Комиссын нэг гишүүн Гомбо Бадамжапов 1922-1924 онд Токиогийн Гадаад хэлний сургуульд монгол хэл зааж байсан. 1924 онд Монголд эргэж ирээд Үндсэн хууль боловсруулах комисст орж ажилласан. Тэрбээр Японы Үндсэн хуулийг авчирсан, орчуулсан байх магадлалтай. “Ил Товчоо”, 1998, № 12 /284/ үз.

Японы 1889 оны Үндсэн хуулийн англи, орос, монгол эхийг харьцуулан үзэх нь

Японы Үндсэн хуулийн англи эх <i>Chapter II Rights and Duties of Subjects</i>	Японы үндсэн хуулийн орос эх <i>2 дугаар бүлэг “Права и обязанности подданных”</i>	Японы Үндсэн хуулийн монгол орчуулга <i>2 дугаар бүлэг “Албат иргэний эрх ба үүргийн тухай”</i>
<i>Article XVIII. The conditions necessary for being a Japanese subject shall be determined by law.</i>	<i>Статья 18-я: Условия, необходимые для состояния в японском подданстве, должны определяться законом.</i>	<i>18-р зүйл: Японы албат болсугай хэмээвээс ямар журам хэрэглэхийг тусгаар хууль дор заажихуй.</i>
<i>Article XIX. Japanese subjects may, according to qualifications determined in laws or ordinances, be appointed to civil or military or any other public offices equally.</i>	<i>Ст.19-я: Японские подданные могут, если удовлетворяют условиям, обозначенным в законах или распоряжениях, быть назначаемы как на военные, так и на гражданские должности, а равно исполнять и другие общественные службы.</i>	<i>19-р зүйл: Японы харьяат ард болбаас хэн ч атугай хууль дүрэм лүгээ нийлэлцэх бөгөөс бичиг цэргийн тушаал дор ба бусад зүйлийн ямар ч албан тушаал дор орж болмуй.</i>
	<i>Ст.20-я: Японские подданные подлежат отбыванию военной или морской службы, согласно определениям закона.</i>	<i>20-р зүйл: Японы албат нар тогтоосон хууль ёсоор хуурай ба усан замын цэргийн алба дор явбаас зохимуй.</i>
<i>Article XXI. Japanese subjects are amenable to the duty of paying taxes, according to the provisions of law.</i>	<i>Ст.21-я: Японские подданные обязаны платить налоги, согласно постановлениям закона.</i>	<i>21-р зүйл: Японы албат нар тогтоосон хууль ёсоор алба гувчуур хураалгаваас зохимуй.</i>
<i>Article XXII. Japanese subjects shall have the liberty of abode and of changing the same within the limits of law.</i>	<i>Ст. 22-я: Японские подданные пользуются свободой выбора местожительства и перемены такого в пределах закона.</i>	<i>22-р зүйл: Японы албат нар хууль ёсоор тогтоосон хязгаар дотор өөрийн дураар шилжих эрх чөлөө буй.</i>
<i>Article XXIII. No Japanese subject shall be arrested, detained, tried or punished, unless according to law.</i>	<i>Ст.23-я: Ни один японский подданный не может быть арестован, удержан в заключении, судим или наказан иначе, как по закону.</i>	<i>23-р зүйл: Японы албат нарыг тухай дор тогтоосон хуулиас гадуур барьж хорих ба гянданд хадгалж байцаан шийтгэж үл болмуй.</i>
<i>Article XXIV. No Japanese subject shall be deprived of</i>	<i>Ст. 24-я: Ни один японский подданный не может быть</i>	<i>24-р зүйл: Японы албат нар хэн ч атугай хуулийн</i>

<i>his right of being tried by the judges determined by law.</i>	лишен права быть судимым судьями, установленными законом.	ёсоор тогтоосон өөрийн харьяат захиргаанд шилжих эрхийг эдлэвээс зохисуй. Энэхүү эрхийг эвдэж үл болмуй.
<i>Article XXV. Except in the cases provided for in the law, the house of no Japanese subject shall be entered or searched without his consent.</i>	Ст. 25-я: Помимо случаев, в законе обозначенных, в дом японского подданного нельзя ни войти, ни произвести там обыск без его согласия.	25-р зүйл: Тусгаар хууль дотор заасан учруудаас гадна Японы албат нарын зөвшөөрөл үгүй бөгөөс журмаар гэр оронд орж болохгүй, гэрийг нэгжиж болохгүй болой.
<i>Article XXVI. Except in the cases mentioned in the law, the secrecy of the letters of every Japanese subject shall remain inviolate.</i>	Ст. 26-я: Помимо случаев, в законе обозначенных, тайна переписки каждого японского подданного не может быть нарушаема.	26-р зүйл: Тусгаар хуулиар заасан зүйлүүдээс гадна Японы албат нарын захидал бичгийг завсраас задлан нээн үзэж болохгүй.
<i>Article XXVII. The right of property of every Japanese subject shall remain inviolate. Measures necessary to be taken for the public benefit shall be provided for by law.</i>	Ст. 27-я: Право собственности каждого японского подданного должно оставаться неприкосновенным. Меры, необходимые в интересах общего блага, должны устанавливаться законом.	27-р зүйл: Японы албат нарын өөр өөрийн өв хөрөнгийн эрх дор халдаж болохгүй. Хэрэв олны тус дор холбогдох хэрэг учир тохиолдвоос өв хөрөнгийг хэрхэн хэрэглэх тухайг тусгай хуулиар тодорхойлон заажихуй.
<i>Article XXVIII. Japanese subjects, shall within limits not prejudicial to peace and order, and not antagonistic to their duties as subjects, enjoy freedom of religious belief.</i>	Ст. 28-я: Японские подданные пользуются свободой вероисповедания, поскольку она не нарушает проядка и спокойствия и не наносит ущерба их обязанностям, как подданных.	29-р зүйл: Японы албат нарын шашин шүтлэгийг олны амгалан төвшинд нийлүүлж хэмжээ төвийг батлахаас гадна албаны үүрэг дор үл харшлахгүйгээр хэмжээ тавьж шашин шүтлэгийн эрх чөлөө олгомуй.
<i>Article XXIX. Japanese subjects shall, within the limits of law, enjoy the liberty of speech, writing, publication, public meetings and associations.</i>	Ст.29-я: Японские подданные, в пределах закона, пользуются свободой слова, письма, печати, общественных собраний и союзов.	29-р зүйл: Японы харьяат ардууд хууль дүрмээр заасан хэмжээний дотор үг хэлэх бичих ба өөрийн санал дэлгэрүүлэх жич олноор эелдэн хуралдах ба хоршоо холбоо байгуулах эрх буй.

<p>Article XXX. Japanese subjects may present petitions, by observing the proper forms of respect, and by complying with the rules specially provided for the same.</p>	<p>Ст.30-я: Японские подданные могут подавать петиции, соблюдая надлежащие почтительные формы и подчиняясь правилам, на сей предмет установленным.</p>	<p>30-р зүйл: Японы албат нар олноор нэр холбон дээд газар өргөдөл бичиг мэдүүлэх эрх буй. Гагцхүү журам ёслолыг зөрчих ба энэ тухай дор тогтоосон хууль зүйлийг зөрчиж болохгүй.</p>
<p>Article XXXI. The provisions contained in the present Chapter shall not affect the exercise of the powers appertaining to the Emperor, in times of war or in cases of a national emergency.</p>	<p>Ст.31-я: Определения настоящей главы не должны влиять на осуществление прав, принадлежащих императору, во время войны или в других неотложных случаях общенациональной важности.</p>	<p>31-р зүйл: Энэхүү бүлгийн доторх зүйлүүд болбаас хэрхэвч байлдаан түгшүүртэй цаг ба дотроо самуурсан цаг дор императорын явуулах эрхийг халж цуцалж үл чадмуй.</p>
<p>Article XXXII. Each and every one of the provisions contained in the preceding Articles of the present Chapter, that are not in conflict with the laws or the rules and discipline of the Army and Navy, shall apply to the officers and men of the Army and of the Navy.</p>	<p>Ст. 32-я: Все и каждое из постановлений, заключающихся в предыдущих статьях настоящей главы, которые не находятся в противоречии с законами или правилами дисциплины в армии и флота, имеют силу также и для офицеров и нижних чинов армии и флота.</p>	<p>32-р зүйл: Энэхүү бүлэг зүйлүүд тус бүрийг хэрэв хуурай ба усан замын цэргийн хууль тогтоол дүрэм дор үл харшлах аваас ийм зүйлүүдийг хуурай ба усан замын цэргийн түшмэд ард нар дор хэрэглэж болмуй.</p>

Эх сурвалж: Японы Үндсэн хуулийн англи, орос эх. Японцы о Японии. Ред. А.Стэд. С-Петербург, 1906. с. 531-532

Үндэсний төв номын санд мөн “Америк, Япон, Англи гурван улсын үндсэн хууль” хэмээх орчуулгын дэвтэр тусдаа хадгалагдаж байна. Энэхүү 96 хуудас орчуулгын эхний хоёр хэсэг нь АНУ, Японы үндсэн хуулийн орчуулга бөгөөд 3-р хэсэг нь “Англи улсын үндсэн хууль”, 4-р хэсэг нь “Улсын хааны эрх”, 5-р хэсэг нь Англи улсын үндсэн хуулиас түүвэрлэн авсан орчуулга байна.⁹ Түүнчлэн 1918 оны РСФСР-ын үндсэн хуулийн монгол орчуулга “Орос нийгэм журамт холбоот бүгд зөвлөлийн засагт бүгд найрамдах улсын үндсэн хууль” гарчигтай Үндэсний төв номын санд мөн хадгалагдаж байна.¹⁰

4. Товч дүгнэлт

Яагаад 1920-иод оны Үндсэн хуулийг боловсруулагчид Мейжийн Японы Үндсэн хуулийг сонирхон судалж, монгол хэлээр орчуулах болов? гэсэн асуулт гарч байна.

⁹ Америк, Япон, Англи гурван улсын Үндсэн хууль. Үндэсний төв номын сан. Шифр 2900/96. Нийт 96 тал.

¹⁰ РСФСР-ын Үндсэн хууль. Үндэсний төв номын сан. Шифр 3191/96. Нийт 26 тал.

Юуны өмнө Мейжийн Япон Эзэн хаантай, Хаан нь хэмжээт цаазтай, мөн Улсын хурал буюу парламенттай улс байсан нь гол шалтгаан болно.

Монголын Үндэсний үзэлтнүүдийн мөрөөдөл бол “Хэмжээт цаазат, ардын эрхт” тогтолцоог хүсэж байв. Тэр нь Англи, Японд байсан шиг Эзэн хаантай парламентын Бүгд Найрамдах Улсыг баримжаалж байсан гэж хэлж болно. Хэмжээт цаазат Эзэн хаан ба Улсын хурал буюу парламентын эрх мэдлийн харьцааны асуудал тухайн үед онцгой анхаарал татаж байв.

Хоёрт, Мейжийн Японы Үндсэн хуульд туссан байсан албат иргэдийн эрх, эрх чөлөөний асуудал манай хууль боловсруулагчдын хувьд үлгэр жишээ болж байсан гэж үзэж болно. Тухайлбал, үг хэлэх, бичих ба өөрийн санал дэлгэрүүлэх, хоршоо холбоо байгуулах эрх (Японы Үндсэн хуулийн 2-р бүлэг, 29-р зүйл), Японы ард хэн ч болов бичиг, цэргийн тушаал эдлэх эрх (19-р зүйл), шашин шүтлэгийн эрх чөлөө эдлэх эрх (Японы ҮХ-ийн 28-р зүйл), Японы албат нарын өөр өөрийн өв хөрөнгийн эрх дор халдаж болохгүй (Японы ҮХ-ийн 27-р зүйл) зэргийг нэрлэж болно.

Д.Бодоогийн боловсруулсан Үндсэн хуулийн анхны төслийн “Ардын эрх ба үүргийн тухай” 2-р бүлэгт Японы Үндсэн хуулиас санаа авсан болов уу гэмээр хэд хэдэн заалт байгаа юм. Үүнд монгол ард эвлэлдэн нэгдэж хоршоо нам байгуулах эрх, эрдэм чадал буй бөгөөс бичиг, цэргийн ямар ч албанд орж болох эрх, шашин мөргөлийн шүтлэгийг үйлдэх эрх чөлөө, монгол ард өөр өөрийн хөдлөх ба хөдлөхгүй хөрөнгийг эдлэх эрх гэх зэргийг дурдаж болно.

5. Эх сурвалж

- МУУТА, ТБА. Х-1, Д-1, ХН-80, х.171-173.
- М.Санждорж. Ардын төрийн түүх. УБ., 1974, х.135-136.
- Ч.Дашидаваа. Улаан түүх (Коминтерн ба Монгол). УБ., 2003, х. 85.
- З.Лонжид. Түүх сөхөхүй. Эмхэтгэл. УБ., 2011, х.351.
- Олон улсын Үндсэн хуулийн оршил ба Англи, Америк, Япон, Норвег улсын үндсэн хуулийн дэвтэр. Үндэсний төв номын сан. Шифр 2898/96 цахим эх. Нийт 102 тал.
- Олон улсын Үндсэн хуулийн оршил ба Англи, Америк, Япон, Норвег улсын үндсэн хуулийн дэвтэр. х. 3-14.
- Магна Харт. Орчуулсан П.Амаржаргал, Редактор Н.Лүндэндорж. УБ., 2012, х.8-9.
- Олон улсын Үндсэн хуулийн оршил ба Англи, Америк, Япон, Норвег улсын үндсэн хуулийн дэвтэр. Үндэсний төв номын сан. Шифр 2898/96 цахим эх. Нийт 102 тал.
- Ил Товчоо, 1998, № 12 /284/
- Америк, Япон, Англи гурван улсын Үндсэн хууль. Үндэсний төв номын сан. Шифр 2900/96. Нийт 96 тал.
- РСФСР-ын Үндсэн хууль. Үндэсний төв номын сан. Шифр 3191/96. Нийт 26 тал.